



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/02

Аргатай

2023 оны шинэчилсэн цэргийн
бүртгэл явуулах тухай

Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт, 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/331 тоот тушаалаар батлагдсан "Цэргийн тоо бүртгэл явуулах журам", Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/552 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны Цэргийн бүртгэл явуулах сумын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Р.Отгонбаатар (ЗДТГ-ын дарга)

Гишүүд: М.Мөнгөнхуяг (1-р багийн Засаг дарга)
Э.Дашдамба (2-р багийн Засаг дарга)
А.Отгонсүрэн (3-р багийн Засаг дарга)
Б.Далхсүрэн (Хэсгийн цагдаа)

2. Сумын цэргийн бэлтгэл алба хаах насны үүрэг бүхий иргэд болон цэргийн жинхэнэ алба хаах насны иргэдийн цэргийн бүртгэлийг 2022 оны 01 дүгээр сарын 03-наас 2022 оны 02 дугаар сарын 01-ний дотор зохион байгуулж явуулахыг комиссын дарга (Р.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

3. Тоо бүртгэлийн үеэр "Батлан хамгаалах"-ын хууль, тогтоомж, цэргийн жинхэнэ болон гэрээт цэргийн албыг сурталчилах ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4. Цэргийн бүртгэлийн ажлыг хүн амын тоо бүртгэлтэй нягт уялдуулан зохион байгуулж, гишүүдийн ажил үүргийн хуваарийг тогтоон, бүртгэл явуулахад шаардлагатай автомашин, ажлын байр, хүн хүчийг гарган ажиллуулсугай.

5. Бүртгэлийг зохион байгуулахтай холбогдуулан иргэд, цэргийн үүрэгтнүүдэд 2016 онд шинэчлэн батлагдсан "Батлан хамгаалах"-ын багц хууль, 2018 онд

батлагдсан “Орон нутгийн хамгаалалтын тухай хууль”, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг биеэр хаах журам” мөн тус оны Засгийн газрын 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Цэргийн гэрээт алба хаах журам” зэрэг бусад холбогдох хууль, эрхзүйн баримт бичгүүдийн тухай, цэргийн жинхэнэ алба хаах тухай хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хэрэгслээр сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг шуурхай зохион байгуулах;

6. Тоо бүртгэлийн зөрчилтэй болон зайлсхийгчид, завсардагчид, урд онуудын болон энэ оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагад хамрагдаагүй цэргийн үүрэгтнүүдийг эрэн сурвалжлах, бүртгэлд хамруулах ажилд Цагдаагийн байгууллага, иргэний бүртгэл мэдээллийн ажилтнууд болон холбогдох албан тушаалтнуудыг татан оролцуулах, тоо бүртгэлийн журам зөрчигчдийн нэрсийг гарган хэнд ямар арга хэмжээ авсан тухай мэдээг заасан хугацаанд аймгийн Цэргийн штабт ирүүлэх.

ДАРГА ЦЭВЭЛМАА

